



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2021/1/СТА-ТБӨӨААН**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaal@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл



## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	16



## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.03.12. № 330

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН ЭРЧИМ  
ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА Ч.ГАНБАТ ТАНАА

#### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

##### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

##### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011020165



**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ





## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
------------	-------------------	----------------	-----------------



1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,219,405.00</u>	<u>6,999,061.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,219,405.00	6,999,061.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,219,405.00	6,999,061.00
3121	Төгрөг	1,219,405.00	6,999,061.00
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31213	Арилжааны банк дахь харилцах	1,219,405.00	6,999,061.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,760,000.00</u>	<u>2,070,000.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,760,000.00	2,070,000.00
392	Биет хөрөнгө	2,760,000.00	2,070,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,450,000.00	3,450,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(690,000.00)	(1,380,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,979,405.00</u>	<u>9,069,061.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,979,405.00</u>	<u>9,069,061.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,979,405.00	9,069,061.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	3,979,405.00	9,069,061.00
51210	Өмнөх үеийн үр дүн	3,582,112.00	3,979,405.00
51220	Тайлант үеийн үр дүн	397,293.00	5,089,656.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,979,405.00</u>	<u>9,069,061.00</u>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,689,873.00	14,438,236.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,689,873.00	14,438,236.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,689,873.00	14,438,236.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
120009	Бусад орлого	7,689,873.00	14,438,236.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,292,580.00	9,348,580.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,292,580.00	9,348,580.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,292,580.00	9,348,580.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	5,120,000.00
210104	Урамшуулал	-	5,120,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,367,780.00
210401	Бичиг хэрэг	-	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,439,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	678,000.00
2105	Нормативт зардал	-	350,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	350,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
2107	Томиллолт, зочны зардал	-	795,000.00
210702	Дотоод албан томиллолт	-	795,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,292,580.00	25,800.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	7,292,580.00	25,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	690,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	-	690,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>397,293.00</u>	<u>5,089,656.00</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>397,293.00</u>	<u>5,089,656.00</u>



### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>7,689,873.00</b>	<b>14,438,236.00</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,689,873.00	14,438,236.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,689,873.00	14,438,236.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	-
120009	Бусад орлого	7,689,873.00	14,438,236.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>6,614,968.00</b>	<b>8,658,580.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,614,968.00	8,658,580.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,614,968.00	8,658,580.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	5,120,000.00
210104	Урамшуулал	-	5,120,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,367,780.00
210401	Бичиг хэрэг	-	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,439,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	678,000.00
2105	Нормативт зардал	-	350,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	350,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
2107	Томилолт, зочны зардал	-	795,000.00
210702	Дотоод албан томилолт	-	795,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,614,968.00	25,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,421,660.00	25,800.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,074,905.00</b>	<b>5,779,656.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-</b>	<b>-</b>
14	Бусад эх үүсвэр	-	-
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>1,074,905.00</b>	<b>5,779,656.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>144,500.00</b>	<b>1,219,405.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,219,405.00</b>	<b>6,999,061.00</b>

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			3,582,112.00	0.00	3,582,112.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	3,582,112.00	0.00	3,582,112.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			397,293.00		397,293.00
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	3,979,405.00	0.00	3,979,405.00



D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	3,979,405.00	0.00	3,979,405.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00		0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	3,979,405.00	0.00	3,979,405.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00		0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	5,089,656.00	0.00	5,089,656.00
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	9,069,061.00	0.00	9,069,061.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	4,399,800	6,614,968	15,815,500	8,658,580
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	4,399,800	6,614,968	15,815,500	8,658,580
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,399,800	6,614,968	15,815,500	8,658,580
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,400,000	-	5,120,000	5,120,000
210104	Урамшуулал	1,400,000	-	5,120,000	5,120,000
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	175,000	-	640,000	-
2104	Хангамж, бараа материалын зардал	1,570,000	-	5,161,500	2,367,780
210401	Бичиг хэрэг	250,000	-	250,000	250,000
210402	Тээвэр, шатахуун	900,000	-	3,491,500	1,439,780
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	420,000	-	1,420,000	678,000
2105	Нормативт зардал	-	-	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250,000	-	350,000	350,000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250,000	-	350,000	350,000
2107	Томилолт, зочны зардал	1,004,800	-	4,544,000	795,000
210702	Дотоод албан томилолт	1,004,800	-	4,544,000	795,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	6,421,660	-	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	6,421,660	-	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	193,308	-	25,800
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	193,308	-	25,800
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,399,800	7,689,873	15,815,500	14,438,236
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	4,399,800	7,689,873	15,815,500	14,438,236
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,399,800	7,689,873	15,815,500	14,438,236
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	1,219,405
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,219,405	-	6,999,061
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	-	-
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	4	4	4	4
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	2	2	2	2
620004	Гэрээт ажилтан	1	1	1	1

## 3. Аудитын тайлан



### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ч.Ганбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 25-аас 2021 оны 03 дугаар сарын 04-ний хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дорнод аймагт эрчим хүчний төрийн бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд зардлаар сонгосон суурь үзүүлэлтийн дүн 7,292.6 мянган төгрөгөөс тооцон 145.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 186.9 мянган төгрөгөөр тооцсон нь 2020 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.

### **3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,089.7 мянган төгрөгөөр буюу 27.9



хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал болон үндсэн хөрөнгийн дансны бууралттай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1219,4	6,999.1	5,779.7
Авлага	0	0	
Урьдчилгаа	0	0	
Бараа материал			
Үндсэн хөрөнгө	3,450.0	3,450.0	0
Элэгдэл	-690.0	-1,380.0	-690.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,979.4</b>	<b>9,069.1</b>	<b>5,089.7</b>
Өр төлбөр	0	0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,979.4	9,069.1	5,089.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,979.4</b>	<b>9,069.1</b>	<b>5,089.7</b>

Авлага дансанд өөрчлөлт ороогүй. Авлагын үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй. Бараа материалын үлдэгдэлгүй

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй.

Өр төлбөр дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй. Өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,069.1 мянган төгрөг болж 6,748.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 6,748.3 мянган төгрөгөөр буюу 87,7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн үйл ажиллагааны орлогод өөрчлөлт гарсан байна. Энэ нь Дорнод аймагт үйл ажиллагаа явуулдаг эрчим хүчний тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 2,056.0 мянган төгрөгөөр буюу 28,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардлууд байна. Энэ нь Засгийн газраас цалин хөлс нэмснээс шалтгаалжээ.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 15,815.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 15,815.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг өөрчлөлгүй баталсан байна.



## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 15,815.5 мянган төгрөгийг өөрийн үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр өөрийн үйл ажиллагаанаас нийт 14,438.2 мянган төгрөгийн орлого олж, урсгал үйл ажиллагаанд 8,658.6 мянган төгрөгийг зарцуулж 6,999.1 мянган төгрөгийн харилцах дансандаа үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,658.6 мянган төгрөг буюу 59,9 хувьтай байгаа нь ХХОАТ-ын зардал 640.0 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2,793.7 мянган төгрөгөөр, томилолтын зардал 3,749.0.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Энэ нь цар тахалтай холбоотой төлөвлөсөн ажил бүрэн хийгдээгүй, тусгай зөвшөөрөлтэй зарим аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

## Нэмэлт санхүүжилт

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгээгүй байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Эрчим хүчний зохицуулах зөвлөл нь шилэн дансанд мэдээ байршуулаагүй бөгөөд Шилэн дансны цахим хуудсанд цэс нээлгээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдаж, зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,154.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,154.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай асуудал гараагүй тул залруулга хийгдээгүй болно.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой болон худалдан авалтын е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй 1,154,5 мянган төгрөгийн зөрчилд тус тус албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Дорнод аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл нь Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд өөрийн байгууллагын цэсийг нээгээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх “*Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна:*” 3.1.5 дахь “*төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч.*” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Тайлант хугацаанд хийсэн 1,154.5 мянган төгрөгийн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь заалт Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.


### Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөхөөр зөрчил илрээгүй.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Шилэн дансны цахим сайтад цэс нээлгэхэд анхаарах.

#### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт



№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд өөрийн байгууллагын цэсийг нээгээгүй	0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ч.Ганбат Б.Батжаргал
1	Тайлант хугацаанд хийсэн 1,154.5 мянган төгрөгийн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй	1,154.5	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ч.Ганбат Б.Батжаргал
<b>ДҮН</b>		<b>1,154.5</b>			